



239

ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар №99

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Эрүүл мэндийн салбарыг дэмжих арга хэмжээний зардлаас шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотоос Шивээговь сумын Эрүүл мэндийн төвд 2 дугаар багийн их эмчээр ажиллаж байгаа Батаагийн Баттөрийн түрээсийн байрны 6 сарын төлбөрт 2,100,000 (хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Арга хэмжээний төсвийн дагуу 2,100,000 (хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3. Б.Баттөрийн түрээсийн байрны ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, 1 жилийн хугацаанд сумын Эрүүл мэндийн төвийн их эмчээр ажиллах талаар гэрээ байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Сувданцэцэг)-т, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг 2 дугаар багийн их эмч (Б.Баттөр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ